# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр | Дугаар А/227 | Булган сум

Ээлжит цэрэг татлага явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны мн/209 дүгээр тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн н/60 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 2023 оны 04 дүгээр сарын 20-оос 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд Булган сумaнд төвлөрүүлэн зохион байгуулж, Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг, Бугат, Сэлэнгэ, Хангал, Хялганат тосгоныг хамруулсугай.

2.Цэрэг татлагын товчоог 1 дүгээр, эмч нарын комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар, цэрэг татлагын эрүүл мэндийн урьдчилсан үзлэг явуулах хуваарийг 3 дугаар, зарцуулах хөрөнгийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталж, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийг хуваарийн дагуу явуулах, цэрэг татлагын ажлыг сайтар зохион байгуулахыг Цэрэг татлагын товчоо (Д.Алтаншагай), Цэргийн штаб (Дэд хурандаа Ч.Энхбаяр), эмч нарын комисс (П.Оюунцэцэг)-т тус тус хариуцуулсугай.

3.2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагад зарцуулах 11,060,000 (арван нэгэн сая жаран мянга) төгрөгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

4.Сумын Эрүүл мэндийн төв, Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж мансууруулах бодисын хамааралтай, энэ төрлийн эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн түүхий эдийг хэрэглэдэг, мансуурах донтой иргэдийн судалгаа, цэрэг татлагаас өмнө сүрьеэгийн сорил тавих ажлыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран өвчилж болзошгүй болон сүрьеэгийн ойрын хавьталтай цэргийн насны залуучуудын судалгааг тус тус гаргаж ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт даалгасугай.

5.Эмнэлгийн үзлэгт орох залуучуудын шинжилгээг Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 1, 6, 7 дугаар зүйлийг үндэслэн зохион байгуулахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

6322010951

(С.Нарантуяа), Эрүүл мэндийн даатгалын тасгийн дарга (Б.Чулуунчимэг) нарт тус тус хариуцуулсугай.

6.Цэрэг татлагын товчоо, эмч нарын комисс сумдад ажиллах, хугацаат цэргийн албанд татагдаж буй иргэнийг тээвэрлэх арга хэмжээг зохион байгуулахдаа хөдөлмөр, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөж, авто техникийн бүрэн бүтэн байдлыг сайтар хангах, хамрагдвал зохих хүмүүсийг бүрэн хамруулан аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хяналтын тоог биелүүлж, цэрэг татлагын ажлыг хугацаанд нь зохион байгуулж, дүнг 2023 оны 05 дугаар сарын 04-ний дотор илтгэхийг Цэрэг татлагын товчоо (Д.Алтаншагай), Цэргийн штаб (Дэд хурандаа Ч.Энхбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 06-ны өдрийн №62 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

# 2023 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧОО

| | |
|---|---|
| Цэрэг татлагын товчооны дарга | Д.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга) |
| Цэрэг татлагын товчооны орлогч дарга | Ч.Энхбаяр (Цэргийн штабын дарга, Дэд хурандаа) |
| Цэрэг татлагын товчооны нарийн бичгийн дарга | Н.Төмөр-Очир (Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, Дэд хурандаа) |
| Цэрэг татлагын товчооны Гишүүд: | Л.Ганбаатар (Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн Хурандаа) |
| | Ш.Баасандорж (Онцгой байдлын газрын дарга, Хурандаа) |
| | С.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын дарга) |
| | П.Оюунцэцэг (Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| | Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга) |
| | Х.Ууганбаяр (Бугат сумын Засаг дарга) |
| | Б.Ууганбаяр (Сэлэнгэ сумын Засаг дарга) |
| | Х.Энхбаатар (Аймгийн ЗДТГ-ын Нийтлэг үйлчилгээний албаны дарга) |
| | Б.Ариунболд (Эрүүл мэндийн даатгалын тасгийн дарга) |
| | Ж.Халиунаа (Хөгжимт жүжгийн театрын дарга) |
| | Б.Намнансүрэн (Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, Хошууч) |
| | Ц.Цэрэнтогтох (Цэргийн штабын дайчилгааны офицер, Хошууч) |

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 06-ны өдрийн А/224 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

ЭМЧ НАРЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| 1. Ерөнхий эмч | М.Билгүүн |
| 2. Дотрын эмч | Б.Наранхүү |
| 3. Мэс засал | Б.Мөнхдэмбэрэл |
| 4. Чих, хамар хоолойн эмч | М.Билгүүн |
| 5. Мэдрэл, сэтгэцийн эмч | Д.Гүндэгмаа |
| 6. Нүдний эмч | М.Давхарбаяр |
| 7. Арьс өнгөний эмч | Ч.Амаржаргал |
| 8. Сүрьеэгийн эмч | Д.Буянхишиг |
| 9. Шүдний эмч | Б.Баярмаа |
| 10. Дүрс оношлогооны эмч | Э.Одмаа |
| 11. Рентген техникч | А.Оюунсувд |
| 12. Ахлах лаборант | Д.Ганганцэцэг |

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 06-ны өдрийн А/221 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

СУМДАД ЦЭРЭГ ТАТЛАГЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛСАН ҮЗЛЭГ
ЯВУУЛАХ ХУВААРЬ

| № | Сумын нэр | Урьдчилсан үзлэг явуулах хугацаа | Үзлэгт орох хүний тоо | Цэргийн жинхэнэ албанд татах хүний тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Сайхан | 04-р сарын 21 | 173 | 18 |
| 2 | Баян-Агт | 04-р сарын 22 | 123 | 20 |
| 3 | Хутаг-Өндөр | 04-р сарын 23 | 188 | 27 |
| 4 | Тэшиг | 04-р сарын 24 | 136 | 18 |
| 5 | Бугат | 04-р сарын 25 | 128 | 18 |
| 6 | Сэлэнгэ | 04-р сарын 26 | 141 | 23 |
| 7 | Хялганат | 04-р сарын 27 | 163 | 20 |
| 8 | Хангал | 04-р сарын 28 | 78 | 14 |
| 9 | Булган | 05-р сарын 01 | 316 | 30 |
| **Бүгд** | | | **1446** | **188** |

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 06-ны өдрийн 122 дугаар
захирамжийн 4 дүгээр хавсралт

## 2023 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГАД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

| № | Зардлын чиглэл | Хөрөнгийн хэмжээ /төг/ | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Цэрэг татлагын товчоо, сумаас цэрэг хүргэж ирсэн хүмүүс, Цэргийн ангиас цэрэг хүргэж ирсэн офицерууд, ЦТБ дээр ажиллах хүмүүсийг хооллох, байрлуулах | 4440000 | 51 хүн 1 өдөрт 20000 төг 2 өдөр хооллоно=2040000 Байр-24*2*50000=2400000 |
| 2 | Цэргийн албанд татагдсан залуучуудыг цэргийн анги байгууллагад хүргэх замд 1 удаа хооллоход | 900000 | 90 хүн 1 удаа (1 хүн 10000 төгрөгөөр хооллоно) |
| 3 | Суманд цэрэг татлагын урьдчилсан үзлэг явуулах, унааны зардал /шатахуун/ | 3024000 | А-92 бензин 1200л*2520 2 машин |
| 4 | Улаанбаатар хотод “БХЯ, ЗХЖШ-т” маш нууц, нууц баримт бичиг хүргэж өгөх унааны зардал /шатахуун/ | 756000 | А-92 бензин 300л*2520 /талон/ |
| 5 | Эмч нарын томилолтын зардалд | 1440000 | 6 эмч 10 хоног*24000 |
| 6 | Бусад зардалд | 500000 | Цэвэр ус, нойтон сальфетка, гар ариутгагч, маск гэх мэт |
| **Бүгд** | | **11,060,000** | |